



**ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ 1980 ОНЫ  
КОНВЕНЦЫН 2005 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Нэгдэн орох үндэслэл, шаардлага**

**1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улс нь 1985 онд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, 1987 онд Цөмийн ослын талаар шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн болон цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенцод тус тус нэгдэн орж, соёрхон баталсан.

2009 онд Монгол Улсын Их Хурлаас Цөмийн энергийн тухай хууль болон “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ыг тус тус баталсан.

Цөмийн энергийн тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан байдаг.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.2.4.4-д “Цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ.” гэж заасан.

Түүнчлэн Улсын Их хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 12 дугаар зүйлд “Монгол Улс олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлнэ.” Мөн тус үзэл баримтлалын 13 дугаар зүйлд “Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулах хүчин чармайлт гаргана.” тус тус заасан байдаг.

Түүнчлэн “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 60 дугаар тогтоолд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй

ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлт болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан болно.

Иймд дээр дурдсан Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов” гэж шийдвэрлэсэн бөгөөд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уг конвенцын нэмэлтийг соёрхон батлах тухай асуудлыг дэмжиж, гарын үсэг зурахыг Засгийн газарт зөвшөөрсөн болно.

Цөмийн энергийн комиссын 2022 оны хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн барих чиглэл өгсөн. Мөн Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох асуудлыг хэлэлцүүлж, хуралдааны 33 дугаар тэмдэглэлд конвенцыг хэлэлцэн дэмжиж Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын нэмэлт өөрчлөлтийг дэмжсэн.

Дээрх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан бөгөөд УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн дараа хэлэлцэхээр шийдвэрлэсэн.

## **1.2. Практик үндэслэл, шаардлага**

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах асуудал анх 1999 онд сөхөгдсөн бөгөөд АНУ-ын Нью-Йорк хотноо 2001 онд болсон террорист халдлагын дараа уг асуудал улам ихээр хөндөгдөх болсон. Энэхүү террорист халдлагад цөмийн материал ашиглаагүй боловч ийм төрлийн аюул заналаас урьдчилан сэргийлэх, улс орон бүр өөрийн цөмийн материал, цөмийн байгууламжийг биечлэн хамгаалах дэглэмийг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж, 2005 онд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцод нэгдэн орсон улс орнууд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод хуралдаж, уг конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн байна.

Олон Улсын Атомын Энергийн Агентлаг нь энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламж, цөмийн материалыг үр дүнтэй биечлэн хамгаалах дэглэмийг дэлхий дахинд бий болгож хэвшүүлэх, цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд энэхүү нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орохыг гишүүн орнуудад уриалсан.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц нь 1987 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 164 улс нэгдэн орж, 44 улс гарын үсэг зурсан ба 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 136 улс нэгдсэн байна.

Манай Улс одоогийн байдлаар их хэмжээний өндөр идэвхтэй цөмийн материал, цөмийн байгууламжгүй хэдий ч өөрийн орны өнөөгийн биечлэн хамгаалах шаардлагыг олон улсын стандартад нийцүүлэх нь зүйтэй байна. Ингэснээр 1986 онд нэгдэн орсон Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцоор хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх боломж үүсэх юм.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулалт, хамрах хүрээ, хүлээх эрх, үүрэг**

Хуулийн төсөлд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай асуудлыг тусгана.

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд 1 дүгээр зүйлд "Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг Монгол улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай" заалт байхаар боловсруулна.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц энхийн зорилгоор ашиглах цөмийн материалыг олон улсын хэмжээнд аюулгүй тээвэрлэх, биечлэн хамгаалахад, конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь энхийн зорилгоор ашиглаж байгаа цөмийн байгууламж, цөмийн материалын үр дүнтэй биечлэн хамгаалах тогтолцоог дэлхий дахинд бий болгож хэвшүүлэх, цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оролцогч талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, ач холбогдол**

Хуулийн төсөл батлагдсанаар цөмийн материалыг хулгайлах, хууль бусаар эзэмших, эдгээр үйлдлээр учирч болох бодит аюул бий болсон тохиолдолд ОУАЭА-т нэн даруй мэдэгдэх, энэхүү мэдээллийг үндэслэж тухайн улс өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, цөмийн террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, бодит аюул тулгарсан тохиолдолд бусад орон болон холбогдох олон улсын байгууллагуудаас дэмжлэг авах боломжтой.

Түүнчлэн уг хуулийг баталснаар цөмийн материал болон цөмийн байгууламжийг биечлэн хамгаалах дэглэмийг олон улсын стандартын дагуу хэрэгжүүлэх, цөмийн терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болох ач холбогдолтой болно.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын хууль тогтоомжтой хэрхэн уялдах, шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдсан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.